

БНСУ-ын Хууль зүйн яам, 2025 оны сайн дураар нутаг буцаж буй гадаадын иргэдэд үзүүлэх тусгай өршөөлийн аян

2025 оны 12 сарын 1-ний өдрөөс эхлэн 2026 оны 2 сарын 28-ны өдрийг хүртэл хууль бусаар оршин сууж байгаа иргэдэд зориулан сайн дураар нутаг буцах гадаадын иргэдийг торгуулиас чөлөөлж, хилээр буцаж орох эрхийг хязгаарлахгүй.

□ **Дэлгэрэнгүй мэдээлэл**

- Хууль бусаар оршин сууж байгаа гадаад иргэдэд зориулан **2025 оны 12 сарын 1-ний өдрөөс эхлэн 2026 оны 2 сарын 28-ны өдрийг хүртэл** сайн дураар нутаг буцах гадаадын иргэдийг **торгуулиас чөлөөлж, хилээр буцаж орох эрхийг хязгаарлахгүй.**

※ Гагцхүү уг хөтөлбөрт хууль бусаар хил нэвтэрсэн, хуурамч гадаад паспорт ашигласан, эрүүгийн н гэмт хэрэгт холбогдсон, хилээр гарах шийдвэрийг хэрэгжүүлээгүй иргэн, 2025 оны 12-р сарын 1-ний өдрөөс хойш хугацаа хэтэрсэн иргэнд хамаарахгүй.

□ **Сайн дураар нутаг буцах үед бүрдүүлэх баримт бичиг**

- Гадаад паспорт, сайн дураар нутаг буцах хуудас(анкет), онгоцны билет

□ **Сайн дураар нутаг буцах урьдчилан мэдэгдэх хүсэлт гаргах журам**

- Сайн дураар нутаг буцах гэж буй гадаадын иргэн өмнөх 「Сайн дураар нутаг буцах урьдчилсан мэдэгдэл」-ийн дагуу эх орондоо буцахаас 3 хоногийн өмнөөс(бүх нийтийн амралтын өдрүүд орохгүй) 15 хоногийн өмнөх(бүх нийтийн амралтын өдрүүд орно) хооронд оршин суугаа газрын харьяа Цагаачлалын албанд өөрийн биеэр очиж урьдчилан мэдэгдэх, эсвэл онлайнаар(<http://www.hikorea.go.kr>) урьдчилан мэдэгдсэний дараа, гарах өдөр 4 цагийн өмнө нисэх буудал дээрх Цагаачлалын албаар орж эцэслэн шалгуулсны дараа гарах.

- Дэлгэрэнгүй мэдээллийг БНСУ-ын Хууль зүйн яамны Гадаад иргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төв (лавлах утас 1345)-ийн тусгай дугаарт холбогдож дэлгэрэнгүй мэдээлэл авахыг зөвлөж байна а. ХайКореа (<http://www.hikorea.go.kr>) болон Цагаачлалын алба, Гадаад иргэдийн бодлого хэрэгжүүлэх төвийн цахим хуудас(<http://www.immigration.go.kr>)-аас үзнэ үү.

Утасны дугаар	Ажлын цаг	Зөвлөгөө авах болон орчуулга хийх боломжтой орны хэл
(☎1345) БНСУ-ын Хууль зүйн яамны Гадаад иргэдийн нэгдсэн зөвлөгөө өгөх төв	09:00~22:00	Англи хэл, Хятад хэл
	09:00~18:00	Япон хэл, Вьетнам хэл, Тайланд хэл, Индонез хэл, Орос хэл, Монгол хэл, Бангладеш хэл, Пакистан хэл, Непал хэл, Камбож хэл, Мьянмар хэл, Франц хэл, Герман хэл, Испани хэл, Филиппин хэл, Араб хэл, ШриЛанка хэл